МОНГОЛ УЛСЫН ШИНЖЛЭХ УХААНЫ АКАДЕМИ
ФИЛОСОФИЙН ХҮРЭЭЛЭН

ФИЛОСОФИЙН ХҮРЭЭЛЭНГИЙН ДУНД ХУГАЦААНЫ СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨ (2017-2025 ОН)

Философийн хүрээлэнгийн Эрдмийн зөвлөлийн
2021 оны 01-р сарын 21-ний өдрийн
хуралдаанаар хэлэлцэн батлав.

Хүрээлэнгийн 2017-2025 оны дунд хугацааны стратеги төлөвлөгөөтэй холбоотой санал, хүсэлтийг дараах утас, факс, и-мэйл хаягаар ирүүлнэ үү.

Утас: 11 330847, 331512
Факс: 11 330846
Email: philo@mas.ac.mn

ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛАЛ

БШУЯ	Боловсрол, Шинжлэх Ухааны Яам
ШУТС	Шинжлэх Ухаан, Технологийн Сан
ШУА	Шинжлэх Ухааны Академи
ТГ	Тэргүүлэгчдийн Газар
ФХ	Философийн хүрээлэн
СХА	Судалгаа хөгжүүлэлтийн ажил
ОХУ	Оросын Холбооны Улс
АНУ	Америкийн Нэгдсэн Улс
БНХАУ	Бүгд Найрамдах Хятад Ард Улс
ЭЗ	Эрдмийн зөвлөл
ШУ	Шинжлэх ухаан
ЭШ	Эрдэм шинжилгээ
БӨ	Баян-Өлгий
МУИС	Монгол Улсын Их Сургууль
СНСЗС	Социологи, нийгмийн сэтгэл зүйн салбар
НҮБ	Нэгдсэн Үндэсний Байгууллага
НҮБХХ	Нэгдсэн Үндэсний Байгууллагын Хөгжлийн хөтөлбөр
ХМХ	Хэвлэл, мэдээллийн хэрэгсэл

Гарчиг

Хураангуй 4

Нэг. Философийн хүрээлэнгийн хөгжлийн төлөв байдлын шинжилгээ, стратегийн чиглэл (SWOT) 6

Хоёр. Философийн хүрээлэнгийн стратегийн загвар 10

Гурав. Үйл ажиллагааны зорилтууд 11

Дөрөв. Үйл ажиллагааны төлөвлөгөө, хэрэгжүүлэх үе шат 13

Тав. Стратеги төлөвлөгөө хэрэгжүүлэгчдийн үйл ажиллагааны уялдаа холбоо 15

Зургаа. Стратеги төлөвлөгөө хэрэгжүүлэхэд шаардлагатай хөрөнгө, санхүүжилтийн эх үүсвэр 17

Долоо. Стратеги төлөвлөгөө хэрэгжүүлэх арга зам 19

Найм. Стратеги төлөвлөгөөний хэрэгжилтийн шалгуур үзүүлэлт 21

Ес. Стратеги төлөвлөгөөний удирдлага, үнэлгээ 24

Хавсралтууд 26

Хавсралт 1. Хүрээлэнгийн түүхэн хөгжил, бүтэц, зохион байгуулалт

Хавсралт 2. Хүрээлэнгийн хүний нөөц

Хавсралт 3. Хүрээлэнгийн бүтээл туурвил

Хавсралт 4. Хүрээлэнгийн санхүүжилт, судалгааны орчин

Хавсралт 5. Хүрээлэнгийн барилга, байгууламж

Хавсралт 6. Үнэт зүйлсийн товч тайлбар

ХУРААНГУЙ

Шинжлэх Ухааны Академийн Философийн хүрээлэн нь Монгол Улсад философи, улс төр судлал, эрх зүй, социологи, нийгмийн сэтгэл зүй, шашин судлалын судалгаа эрхлэх нийгэм, хүмүүнлэгийн салбарын эрдэм шинжилгээний төв байгууллага юм.

Хүрээлэнгийн дунд хугацааны стратегийн төлөвлөгөө нь Монгол Улсын шинжлэх ухаан, технологийн талаар баритлах бодлогын хүрээнд хүрээлэнгийн эрдэм шинжилгээ, үйл ажиллагааны зорилт, арга хэмжээ, тогтвортой хөгжих үндсийг тодорхойлж байна.

“Алсын хараа -2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичиг, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль, Шинжлэх ухаан, технологийн тухай хууль, Шинжлэх ухаан технологийн талаар төрөөс баримтлах бодлого, хүрээлэнгийн түүхэн хөгжил, өнөөгийн байдалд хийсэн дүн шинжилгээг үндэс болгон “Философийн хүрээлэнгийн дунд хугацааны стратегийн төлөвлөгөө (2017-2025)”-г боловсруулав.

Хүрээлэнгийн алсаа хараг Монгол Улсад нийгэм, хүмүүнлэгийн ухааны хүрээнд судлагдаж буй суурь болон хавсарга судалгааг тэргүүлэн гүйцэтгэх, олон улсын жишигт хүрэх зорилго дэвшүүлэн ***“Чанартай эрдмийн бүтээлээр эх орон, ард түмэндээ үйлчлэх”***; “Эрхэм зорилго”-ыг ***“Нийгэм, хүмүүнлэгийн ухааны онол, арга зүйн тэргүүний ололтын үндсэн дээр Монголын нийгмийн хөгжлийн зангилаа асуудлыг судлан, үр дүнг түгээн дэлгэрүүлэх, төрийн бодлогод тусгах, салбар дундын судалгаа хөгжүүлэлтийн ажилд идэвхитэй оролцоход оршино”*** хэмээн тодорхойлж байна.

Хүрээлэнгийн эрдэм шинжилгээний тэргүүлэх чиглэл:

Монгол Улсад философи, социологи, улс төр судлал, улс төрийн эдийн засаг, эрх зүй, шашин судлалын суурь судалгааг хөгжүүлэх

Хүрээлэнгийн үйл ажиллагааны үндсэн чиглэлийг:

- Монгол Улсад философи, улс төр судлал, эрх зүй, социологи, шашин судлалын салбарыг тогтвортой хөгжүүлэхэд хувь нэмэр оруулах;
- Монголын нийгэм, хөгжил, оюун санааны хүрээний асуудлыг философи, улс төр судлал, эрх зүй, социологи, улс төрийн эдийн засаг, нийгмийн сэтгэл зүй, шашин судлалын үүднээс судалж шинжлэх ухааны үндэстэй дүгнэлт гаргаж, цаашдын чиглэл, арга замыг тодорхойлсон үндэслэл боловсруулах;
- Үндэсний болон олон улсын монгол судлал дахь философи, нийгэм, улс төрийн судалгааны чиглэлийг хөгжүүлэхэд хувь нэмэр оруулах;
- Судалгааны үр дүнгээр төрийн бодлого боловсруулах, нийгмийн соён гэгээрэлд дэмжлэг үзүүлэх явдал гэж үзлээ.

Тус стратегийн төлөвлөгөөнд 2017-2025 онд хүрээлэнгийн хамт олноос хэрэгжүүлэн бодит үр дүнд хүрэх зорилтыг дараах дөрвөн багцад нэгтгэн тодорхойлов. Үүнд:

1. Хүрээлэнгийн менежментийн чадавхыг бэхжүүлж, хүний нөөцийг хөгжлийг бэхжүүлнэ.

2. Суурь судалгааны тэргүүлэх чиглэлийг шинэчлэн тодорхойлж, эрдэм шинжилгээний ажлын үр дүнг олон улсын жишигт нийцүүлэн салбар дундын судалгаа хөгжүүлэлтийг дэмжинэ.

3. Гадаад харилцаа, хамтын ажиллагааг өргөжүүлнэ.

4. Судалгаа хөгжүүлэлтийн ажлын таатай орчин бүрдүүлнэ.

5. Мэдээллийн технологийн ололтод түшиглэн судалгааны үр дүнг нийгэмд түгээн, нийгмийн соён гэгээрэлд хувь нэмэр оруулна.

Хүрээлэнгийн стратеги төлөвлөгөөг 2017-2021 он, 2022-2025 он гэсэн хоёр үе шатанд судалгаа шинжилгээний ажлын үр дүнг баримжаалж, түүнд хүрэх арга замуудыг шинжлэн тодорхойлсон болно.

Стратеги төлөвлөгөөний гүйцэтгэлийг 4 жил тутам шалгуур үзүүлэлтүүдийн дагуу хэмжиж тайлагнана. Төлөвлөгөөний биелэлт, түүнд хийсэн дүн шинжилгээг үндэслэн стратеги төлөвлөгөөг сайжруулан шинэчилж байх болно.

Стратеги төлөвлөгөөг Философийн хүрээлэнгийн салбарын эрхлэгч нар, ажилтнууд хамтран боловсруулав.

Стратеги төлөвлөгөөг 2017 оны 05 дугаар сарын 08-нд болсон Монгол Улсын Шинжлэх ухааны Академийн Тэргүүлэгчдийн хурлаар хэлэлцүүлсэн болно.

Стратеги төлөвлөгөөг 2021 оны 01 дүгээр сарын 08-ны өдрийн Захирлын А02 дугаар тушаалаар томилогдсон ажлын хэсэг шинэчлэн сайжруулав.

2021 оны 01 дүгээр сарын 21-ний өдрийн Эрдмийн зөвлөлийн хурлаар хэлэлцэн батлав.

Нэг. ХҮРЭЭЛЭНГИЙН ХӨГЖЛИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ШИНЖИЛГЭЭ (SWOT)

1.1. Хүрээлэнгийн судалгаа хөгжүүлэлтийн ажлын онол, арга зүйн түвшин

Хүрээлэн Философи, Социологи, ниймийн сэтгэл зүй, Улс төр, эрх зүй, Шашин судлалын салбар, Улс төрийн эдийн засгийн ухааны тасагтай бөгөөд Монголын философийн түүх; буддын философийн эх сурвалж; монголын нийгэм-улс төрийн сэтгэлгээний өөрчлөлт, улс төрийн төлөв, хандлага; Монголын нийгмийн бүтэц, давхраажилтын талаарх социологийн шинжилгээ; өрнө-дорны философийн харьцуулалт, Монгол дахь зах зээлийн эдийн засгийн хөгжлийн асуудал зэрэг чиглэлээр судалгаа хийж ирсэн. Хүрээлэнгийн судалгаа шинжилгээний онол, арга зүй хэрхэн өөрчлөгдөн шинэчлэгдэж ирсэн үйл явцыг1978-1990 он, 1990 оноос одоог хүртэлх гэсэн үе шатанд хувааж болно.

Нийгмийн философи, ёс зүй, соёл иргэншлийн онол, өрнө-дорнын философийн харьцуулсан судалгаа нь судалгааны гол чиглэл болж ирсэн. Мөн эртний Грекийн сонгодог философичдын зарим зохиолыг орчуулж эх хэлээрээ уншиж судлах, их дээд сургуулийн сургалт, эрдэм шинжилгээний ажлын зорилгоор ашиглахад тулгуур хэрэглэгдэхүүн болгох, эрдэм шинжилгээний тайлбаруудаар баяжуулж олон нийтэд түгээн сурталчлахад[1] анхааран ажиллаж буй. Одоо дэлхий дахины болон өөрийн орны философи сэтгэлгээний түүхийг судлан боловсруулах, монголын нийгмийн хөгжил, өөрчлөлт, шинэчлэлтийн философийн асуудалд голлон анхаарч эрдэм шинжилгээний үйл ажиллагааг чиглүүлж байна.

Монголын нийгмийн хөгжил, өөрчлөлтийн асуудал; олон нийтийн санаа бодлын өөрчлөлт; Монголын улс төрийн тогтолцооны онцлог; ардчиллын төлөвшил ба түүхийн асуудал; улс төрийн соёлын төлөвшлийн асуудлыг судалгааны үндсэн чиглэл болгон судлахын зэрэгцээ нийгмийн улс төрийн харилцааны чухал асуудлууд[2] болох сонгууль, сонгуулийн тогтолцоо, Монголын улс төрийн сэтгэлгээний түүх, улс төрийн нам, улс төрийн соёл, иргэний нийгмийн төлөвшилт, ардчиллын онолын асуудлууд зэрэг даяаршиж буй нийгмийн хөгжлийн чухал асуудлуудыг улс төрийн аспектаар[3] нарийвчлан судалж байна.

Нийгмийн давхраажил, бүтцийн талаарх социологийн онолын болон суурь судалгааны ажлыг тоон, чанарын шинжилгээ, контент анализ, аман түүх зэрэг арга зүйг хэрэглэн явуулж, нийгмийн давхраажилт, бүтцийг илүү нарийн судалж, өнгөрсөн түүх, ирээдүйн хөгжлийн хандлагыг тодорхойлсон. Одоо Монголын нийгмийн оюун санааны амьдралын өөрчлөлт, залуучууд, ахмад үеийн социологийн асуудал, хотжилт, хөдөөгийн амьдралын хэв маягийн асуудлыг судалж байна. Цаашид философи, социологи, нийгмийн сэтгэл зүй, шашин судлал, улс төр судлал, хууль зүйн шинжлэх ухааны суурь болон хавсарга судалгааг нөөц, боломжийн хүрээндээ хэрэгжүүлэх боломжтой.

Монголын философийн түүхийн судалгааг монголчуудын ертөнцийг үзэх үзэл, философи сэтгэлгээний үүсэл, төлөвшил, түүний хөгжлийн үндсэн үе шатууд дахь үзэл санааны урсгалууд, гол сэтгэгчдийн үзэл баримтлал, бүтээлүүдийг тусгайлан судлах зорилгын хүрээнд гүнзгийрүүлэн явуулж байна. Тэр дундаа онолын болон эх сурвалж судлал гэсэн хоёр үндсэн чиглэлээр Монголын буддын философийн судалгааг өргөжүүлэх ажлыг гүйцэтгэж байна.

---

[1] Даш-Ёндон Б. Эртний грекийн философи сэтгэлгээний эх сурвалж. 3 боть. ШУА. ФСЭХ. УБ., 2011.
[2] Улс төр судлалын салбар. Монголын ардчиллын төлөвшил. ШУА. ФСЭЗХ. ХЗҮХ-ийн хэвлэх. УБ., 2011.
[3] Монгол Улс дахь төлөөллийн ардчилал ба иргэдийн улс төрийн оролцоо. ШУА. ФСЭХ. Соёмбо принтинг. УБ., 2017.

Монгол дахь зах зээлийн эдийн засгийн хөгжлийн судалгаанд сонгодог болон шинэ улс төрийн эдийн засгийн ухаан, экономикс болон эконометриксийн онол, арга зүйг хослон хэрэглэх оролдлого хийж, уг чиглэлээр зарим бүтээлийг гаргав.[1]

Хүрээлэнгийн эрдэмтэд суурь болон хавсарга судалгааны төсөл, үндэсний болон олон улсын томоохон төслүүдийг хамтран хэрэгжүүлж ирсэн.

1.2. Хүрээлэнгийн хөгжлийн төлөв байдлын шинжилгээ (SWOT), стратегийн чиглэл

Хүрээлэнгийн хөгжлийн төлөв байдлыг SWOT анализ ашиглан шинжлэв. Үүнд хүрээлэнгийн салбарууд эрдэм шинжилгээний ажил хийхэд ямар давуу ба сул талтай, тэр нь юугаар илрэх, ямар нөхцөл боломжтой, түүнийг хэрхэн ашиглах, тулгамдаж буй ямар асуудал бий, тэдгээрийн үзүүлэх эрсдэл зэргийг тусгав.

1.2.1. Хөгжлийн төлөв байдлын шинжилгээ

Хүрээлэнгийн хөгжлийн төлөв байдлын шинжилгээ	
ДАВУУ ТАЛ– STRENGTHS	*СУЛ ТАЛ– WEAKNESSES*
• Тус хүрээлэн нь нийгэм, хүмүүнлэгийн ухааны судалгааны чиглэлээр 50 орчим жилийн хугацаанд онолын болон хэрэглээний суурь судалгаа явуулж судалгааны мэдээллийн баялаг санг бүрдүүлсэн. • Энэ мэдээллийн санг тогтмол өргөжүүлэн баяжуулах үндсэн дээр тус улсад философи, улс төрийн шинжлэх ухаан, эрх зүй, социологи, шашин судлал, улс төрийн эдийн засгийн ухааныг хөгжүүлэх, Монголын хөгжлийн төлөв, тулгамдсан асуудлыг иж бүрэн шинжлэн боловсруулах, нэгтгэн дүгнэх, шийдвэрлэх онол, арга зүйн үндэслэлийг дэвшүүлж, төрийн бодлогод тусгахад дэмжлэг үзүүлэх бүрэн боломжтой. • Нийгэм, хүмүүнлэгийн дээрх шинжлэх ухааны чиглэлээр гадаад, дотоодын их сургууль төгссөн, боловсролын болон эрдмийн зэрэг хамгаалсан, судалгааны ажлын дадлага туршлага эзэмшсэн болон эзэмшиж байгаа ахмад, дунд, залуу үеийн хамтарсан баг бүрэлдсэн. • Герман, англи, орос, хятад, төвөд, санскрит хэлтэй эрдэм шинжилгээний ажилтнууд бий.	• Хүрээлэнгийн салбаруудын судалгааны ажлыг уялдуулах, Монголын нийгмийн хөгжлийн асуудлыг тал бүрээс нь иж бүрэн судлах, хамтын бүтээл гаргах талаар зохион байгуулалтын ажил хангалтгүй байна. • Салбаруудын боловсон хүчний чадавх, нөөц харилцан адилгүй, залуу судлаачдын мэргэжилдээ өсөн туршлагажих явдал удаашралтай байна. • Эрдэм шинжилгээний ажилтнуудын гадаад хэлний мэдлэгийг дээшлүүлэх, тэдэнд орчин үеийн онол арга зүйг эзэмшүүлэх, инноваци нэвтрүүлэх, судалгаа хөгжүүлэлтийн ажлын бүтээмж, үр дүнг сайжруулах шаардлагатай байна. • Хүрээлэнгийн бүтээл, оюуны бүтээгдэхүүний сурталчилгаа, борлуулалт сул, зах зээл, маркетинг тааруу, гадаад санхүүжилт олж авч чадахгүй байгаа нь өрсөлдөх чадварыг бууруулж байна. Бизнесийн болон бусад байгууллагуудын захиалгаар гэрээт судалгаа шинжилгээний ажлыг явуулж үр дүнг шууд хүртэх шаардлагатай. • Хүрээлэнгийн төсвөөс гадуурх нэмэлт орлогыг бүрдүүлэх, тэр орлогоороо судалгааны багаж, тоног төхөөрөмж авах, ажилтныг урамшуулах, асуудлыг тэр бүр шийдэх боломжгүй байна. • Хэдийгээр хүрээлэнгийн дэргэд гарааны компани байгуулах эрх зүйн орчин бий болсон ч түүнийг амьдралын бодит нөхцөл байдалд ойртуулан хэрэгжүүлэх шаардлагатай.

[1] Монголын эдийн засгийн хөгжлийн асуудал. ШУА-ийн Философийн хүрээлэн. УБ.,2018, Батхишиг Б. Монгол дахь зах зээлийн эдийн засгийн хөгжлийн асуудлууд. ШУА-ийн Философийн хүрээлэн. УБ.,2020.

БОЛОМЖ - OPPORTUNITIES	*ЭРСДЭЛ -THREATS*
• Хүрээлэнгийн судалгаа шинжилгээний гол үйл ажиллагаа нь онолын суурь судалгаа юм. Орчин үеийн философийн тэргүүлэх чиглэл ба монголын философийн харьцуулсан судалгаа, монголын нийгмийн хөгжил, өөрчлөлтийн философи шинжилгээ, даяаршлын нөхцөл дэх иргэний нийгэм, иргэншлийн төлөвшил, хөгжлийн асуудал, монгол хүний ахуй, үнэлэмжийн философийн судалгаа талаар суурь судалгаа хийж ирсэн туршлага, уламжлалтай. • Улс төр, эрх зүйн орчин үеийн хөгжлийн хандлага, онол арга зүйд тулгуурлан Монголын улс төрийн тогтолцоо, нийгмийн улс төрийн ухамсар, соёлын төлөвшлийн талаар судалгааг явуулж ирсэн бөгөөд цаашид шинэ нөхцөл дэх тэдгээрийн хөгжлийн төлөв, хандлагыг шинжлэх бүрэн боломжтой. • Монголын нийгэмд гарч буй нийгэм, соёлын өөрчлөлтийг социологийн шинжлэх ухааны сүүлийн үеийн онол, арга зүйг хэрэглэн судалж ирсэн туршлагадаа тулгуурлан нийгмийн томоохон институтууд, нийгмийн харилцаанд гарч буй өөрлөлт, нийгмийн бүтэц, давхраажилт, нийгмийн бүлгүүдийн хувирал, төлөвшил, нийгмийн оюун санааны өөрчлөлтийг тандан судалж, дүгнэлт, таамаглал хийнэ. • Төвөд, санскрит хэлний мэдлэгтэй, буддын философи, логикийн мэргэжил эзэмшсэн судлаачдын баг бүрдсэн бөгөөд шашин судлал болон буддын философийн онол, арга зүйг хөгжүүлэх, Монгол дахь дахь шашны нөхцөл байдал, монголчуудын шашин шүтлэг, шашингүй үзлийн судалгааг явуулах боломжтой. • Монголын эдийн засгийн хөгжлийн явц, хандлагыг судлан, түүнийг хурдасгах, хүн амын амьжиргааны түвшин, чанарыг дээшлүүлэх онол, арга зүйн үндэслэлийг боловсруулах чадавх бий болж байна. • Монголын нийгмийн хөгжлийн асуудлыг иж бүрэн судлах төсөл хэрэгжүүлэх, дэлхийн шинжлэх ухааны түвшинд үнэлэгдэх судалгаа шинжилгээний ажил хийх боломжтой.	• Шинжлэх ухаан, технологийн салбарт төрөөс зарцуулж буй санхүүжилт хангалттай бус. Эрдэмтэн судлаачийн цалин хөлс хангалттай бус, эрдэм шинжилгээний ажилтны хэвийн амьдралыг хангахад хүрэлцдэггүй. • Шинжлэх ухаан, үйлдвэрлэл, бизнес, төрийн бодлогын уялдаа холбоо сул. Энэ холбоог сайжруулах механизм бүрдээгүй. Зах зээлийн харилцааны тогтолцооны үед шинжлэх ухааны менежмент хийх менежерүүд бэлтгэгдээгүй, онолын судалгааны үр дүнг үйлдвэр практикт нэвтрүүлэх талаар хангалттай ажиллаж чаддаггүй. • Дээд боловсрол, шинжлэх ухааны байгууллагын уялдаа, холбоо хангалтгүй. Их, дээд сургуулийн багшийн сургалтын ачаалал их, судалгаа хийх цаг бага. Хүрээлэнгийн ажилтнууд сургалтын үйл ажиллагаанд оролцох боломж хязгаарлагдмал. • Эрдэм шинжилгээний ажилтнуудыг гадаадад магистр, докторын сургалтад хамруулах нөхцөл боломж хангалтгүй. • Гадаадад сурч байгаа болон эрдэм шинжилгээний ажил хийж буй залуу мэргэжилтэн, судлаачид ажлын байр, амьдралын баталгаа байхгүйн улмаас эх орондоо буцаж ирээд шинжлэх ухааны байгууллагад ажиллах сонирхол багатай.

1.2.2. Богино, дунд, урт хугацааны стратегийн чиглэл

SO - Хүрээлэнгийн давуу талд тулгуурлан + гадаад орчны таатай боломжийг сайн ашиглах **БОГИНО ХУГАЦААНЫ СТРАТЕГИ:**	**WO - Хүрээлэнгийн сул талыг бууруулан + гадаад орчны таатай боломжийг сайн ашиглах** **ДУНД ХУГАЦААНЫ СТРАТЕГИ:**
➢ ШУА-ийн хэмжээнд мөрдөх дүрэм, журам, Шинжлэх ухаан, технологийн талаарх хууль, тогтоомжийн өөрчлөлтөд нийцүүлэн хүрээлэнгийн дүрэм, журамд нэмэлт өөрчлөлт оруулах; ➢ Эрдэм шинжилгээний тэргүүлэх чиглэлийг шинэчлэн тодорхойлох; ➢ Уламжлалт харилцаатай ОХУ, БНХАУ-ын эрдэм шинжилгээний байгууллагатай хамтарсан төслүүдийн тоог нэмэгдүүлэх; ➢ Хүрээлэнгийн суурь болон хавсарга судалгааны сэдэв, эрдэм шинжилгээний ажилтнуудын оюуны нөөцийг нийгмийн хөгжлийн бодлогын онолын үндэслэлийг боловсруулахад ач холбогдол бүхий үр дүн гаргахад төвлөрүүлэх; ➢ Салбар дундын судалгааг хөгжүүлэх зохион байгуулалтыг сайжруулах.	➢ Боловсон хүчний авьяасыг тэтгэж, ур чадварыг дээшлүүлэх урт, богино хугацааны сургалтуудыг тогтмол зохион байгуулах; ➢ Залуу эрдэм шинжилгээний ажилтнуудыг гадаад, дотоодын их дээд сургуульд докторантурт суралцахыг дэмжих; ➢ Эрдэм шинжилгээний ажилтнуудын судалгааны арга зүй, гадаад хэлний мэдлэгийн түвшинг дээшлүүлэх замаар судалгаа хөгжүүлэлтийн ажлын бүтээмж, үр дүнг сайжруулах ёс зүйн шаардлагыг нэмэгдүүлэх; ➢ Хүрээлэнгийн эрдэм шинжилгээ, үйл ажиллагааны талаарх мэдээ, мэдээллийг олон нийтэд түгээн дэлгэрүүлэн байгууллагын нэр хүндийг өргөх.
ST- Хүрээлэнгийн давуу талд тулгуурлан + гадаад орчны таагүй нөхцөлийн сөрөг нөлөөг арилгах **ДУНД ХУГАЦААНЫ СТРАТЕГИ:**	**WT- Гадаад орчны таагүй нөхцөлд Хүрээлэнгийн сул талаа засах замаар гарах сөрөг үр дагаварыг аль болох багасгах** **УРТ ХУГАЦААНЫ СТРАТЕГИ:**
➢ Хүрээлэнгийн хүний нөөцийн шалгуурт нийцсэн ажилтныг сонгож ажиллуулах журмыг боловсруулах; ➢ Бусад байгууллагын хэрэгжүүлж буй төсөлд удирдагч, гүйцэтгэгчээр ажиллах оролцоог нэмэгдүүлэх; ➢ Хүрээлэнгийн мэдээллийн төвд шаардлагатай номын сан, архивын программ хангамжийг ашиглах; ➢ Хүрээлэнгийн бүтээл, оюуны бүтээгдэхүүнийг хэрэглээнд нэвтрүүлэх маркетингийн төлөвлөлт хийх. ➢ ЕБС-ийн сурагчдад зориулсан хялбаршуулсан гарын авлага, сурах бичиг боловсруулж, тэдний шинжлэх сэтгэлгээний төлөвшилд хувь нэмэр оруулах.	➢ ШУА-ийн эрдэм шинжилгээний ажилтны залгамж халааг бэлтгэх талаар тусгай хөтөлбөрүүдэд тууштай судалгааны ажил хийх залуу ажилтнуудыг хамруулах; ➢ Судалгааны мэдээллийн баримтжуулалттай, нээлттэй цахим сан бүрдүүлэх; ➢ Бизнесийн болон бусад байгууллагуудын захиалгат судалгааг нэмэгдүүлэх замаар хүрээлэнгийн төсвөөс гадуурх нэмэлт орлогыг нэмэгдүүлэх; ➢ Хүрээлэнгийн дэргэд зөвлөх үйлчилгээний гарааны компани байгуулах.

Хоёр. ФИЛОСОФИЙН ХҮРЭЭЛЭНГИЙН СТРАТЕГИЙН ЗАГВАР

АЛСЫН ХАРАА

Монгол Улсад нийгэм, хүмүүнлэгийн ухааны хүрээнд судлагдаж буй суурь болон хавсарга судалгааг тэргүүлэн гүйцэтгэх, олон улсын жишигт хүрэх зорилго дэвшүүлэн
“Чанартай эрдмийн бүтээлээр эх орон, ард түмэндээ үйлчлэх”

ҮНЭТ ЗҮЙЛС



ЭРХЭМ ЗОРИЛГО

Нийгэм, хүмүүнлэгийн ухааны онол, арга зүйн тэргүүний ололтын үндсэн дээр Монголын нийгмийн хөгжлийн зангилаа асуудлыг судлан, ур дүнг түгээн дэлгэрүүлэх, төрийн бодлогод тусгах, салбар дундын судалгаа хөгжүүлэлтийн ажилд идэвхитэй оролцоход оршино.

Стратегийн зорилтууд:

I. Хүрээлэнгийн менежментийн чадавхыг бэхжүүлэх

II. Онолын судалгааны түвшинг дээшлүүлж, шинэ мэдлэг бий болгох

III. Хүний нөөцийн чадавхыг дээшлүүлэх

IV. Судалгаа хөгжүүлэлтийн ажил эрхлэх таатай орчин бүрдүүлэх

V. Гадаад харилцаа, хамтын ажиллагааг өргөжүүлэх

VI. Судалгааны үр дүнг нийгэмд түгээн дэлгэрүүлэх, нийгмийг соён гэгээрүүлэхэд дэмжлэг үзүүлэх

Гурав. ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗОРИЛТУУД

№	Стратегийн зорилтууд	Үйл ажиллагааны зорилтууд
I	Хүрээлэнгийн менежментийн чадавхыг бэхжүүлэх	1.1. Хүрээлэнгийн үйл ажиллагааны төлөвлөлт, зохион байгуулалт, хяналтын тогтолцоог сайжруулна.
		1.2. Хүрээлэнгийн үйл ажиллагааны санхүүжилтийн эх үүсвэрийг нэмэгдүүлж, олон улсын байгууллага, хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтыг дэмжинэ.
		1.3. Эрдэм шинжилгээний тэргүүлэх чиглэлийг шинэчлэн тодорхойлно.
		1.4. Их дээд сургууль, төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтын ажиллагааг өргөжүүлнэ.
II	Онолын судалгааны түвшинг дээшлүүлж, шинэ мэдлэг бий болгох	2.1. Философийн онол, түүхийн судалгаа хийх
		2.2. Монголын нийгэм, хөгжлийн философийн судалгаа хийх
		2.3. Монголын философи сэтгэлгээний түүхийн судалгаа хийх.
		2.4. Монголын нийгмийн болон сэтгэл зүйн өөрчлөлт, төлөв, хандлагыг судлах.
		2.5. Ардчилал-засаглалын орчин үеийн хөгжлийн төлөв, хандлагыг судлах.
		2.6. 1990-ээд оноос хойших Монголын улс төрийн тогтолцооны өөрчлөлтийг судлах.
		2.7. Үндсэн хуулийн эрх зүйн судалгаа хийх.
		2.8. Монгол дахь шашин шүтлэгийн төлөв, хандлагыг судлах
III	Хүний нөөцийн чадавхыг дээшлүүлэх	3.1. Ажилтнуудыг эрдмийн зэрэг хамгаалах, мэргэжил дээшлүүлэх сургалтад хамрагдахыг дэмжих.
		3.2. Судалгааны онол, арга зүйг эзэмших, мэдлэг, мэдээлэл, туршлага солилцох нөхцөлийг бүрдүүлэх.
		3.3. Гадаад, дотоодын байгууллагын төсөл, хөтөлбөрт оролцохыг дэмжих.
IV	Судалгаа хөгжүүлэлтийн ажил эрхлэх таатай орчин бүрдүүлэх	4.1. Хүрээлэнгийн мэдээллийн төвийг үйл ажиллагааг сайжруулах.
		4.2. Хүрээлэнгийн эрдэм шинжилгээний бүтээлийн цахим сан үүсгэх.
		4.3. Тоон болон чанарын судалгааны шинэ программ хангамжуудыг ашиглах
V	Гадаад харилцаа, хамтын ажиллагааг өргөжүүлэх	5.1. Олон улсын болон гадаадын байгууллагатай хамтарсан төслийн тоог нэмэгдүүлэх.
		5.2. Олон улсын мэргэжлийн байгууллага, холбоо, нийгэмлэгийн гишүүнээр элсэх.
		5.3. Гадаадын байгууллагуудтай хамтарсан судалгааг өргөжүүлж, харилцан мэдээлэл, туршлага солилцох.
VI	Судалгааны үр дүнг нийгэмд түгээн дэлгэрүүлэх, нийгмийг соён гэгээрүүлэхэд дэмжлэг үзүүлэх	6.1. Судалгааны үр дүнг хялбаршуулан таниулах замаар хэрэглээнд нэвтрүүлэх.
		6.2. Судалгааны үр дүнг сургалт, судалгаа, хэрэглээний эргэлтэд оруулах.
		6.3. Хүрээлэнгийн эрдэм шинжилгээ, үйл ажиллагааны талаарх мэдээ, мэдээллийг олон нийтэд түгээн дэлгэрүүлэх.

Дөрөв. ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ, ХЭРЭГЖҮҮЛЭХ УЕ ШАТ

Үйл ажиллагааны зорилтууд	Хэрэгжүүлэх төлөвлөгөөт арга хэмжээ	Уе шат	
		I шат: 2017-2021	II шат: 2022-2025
I стратеги зорилт: Хүрээлэнгийн менежментийн чадавхыг бэхжүүлэх			
1.1. Хүрээлэнгийн үйл ажиллагааны төлөвлөлт, зохион байгуулалт, хяналтын тогтолцоог сайжруулах.	1.1.1. ШУА-ийн хэмжээнд мөрдөх дүрэм, журам, Шинжлэх ухаан, технологийн талаарх хууль, тогтоомжийн өөрчлөлтөд нийцүүлэн Хүрээлэнгийн дүрэм, журамд нэмэлт өөрчлөлт оруулж, чанад мөрдөж ажиллана.	+	+
	1.1.2. Хүрээлэнгийн захирлын мөрийн хөтөлбөр, жил бүрийн үр дүнгийн гэрээг боловсруулж хэрэгжүүлнэ.	+	+
	1.1.3. Стратеги төлөвлөгөөний зорилтуудыг биелүүлж, гүйцэтгэлд хяналт тавьж ажиллана.	+	+
1.2. Хүрээлэнгийн үйл ажиллагааны санхүүжилтийн эх үүсвэрийг нэмэгдүүлэх.	1.2.1. Хувийн хэвшлийн байгууллагатай хамтран ажиллах гэрээ байгуулах.	+	+
	1.2.2. Гадаадын төсөл, хөтөлбөрийн тоо, санхүүжилтийн хэмжээг нэмэгдүүлэх замаар бүс нутаг, олон улсад эзлэх байр сууриа бэхжүүлэх.	+	+
	1.2.3. Онолын суурь судалгааны төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэхэд шаардлагатай санхүүжилтийг нэмэгдүүлэх.		
1.3. Эрдэм шинжилгээний тэргүүлэх чиглэлийг шинэчлэн тодорхойлох.	1.3.1. Монгол Улсад философи, социологи, улс төр судлал, улс төрийн эдийн засаг, эрх зүй, шашин судлалын суурь судалгааг хөгжүүлэх	+	
1.4. Их дээд сургууль, төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтын ажиллагааг өргөжүүлэх.	1.4.1. Эрдэм шинжилгээний хурал, семинар, сургалт зохион байгуулах, хамтарсан төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх, сургалтын үйл ажиллагаанд оролцох боломжийг бүрдүүлэх.	+	+
II стратеги зорилт: Онолын судалгааны түвшинг дээшлүүлж, шинэ мэдлэг бий болгох			
2.1. Философийн онол, түүхийн судалгаа хийх.	2.1.1. Философийн эх зохиолын эрдэм шинжилгээний орчуулга, тайлбар судалгаа хийх.	+	+
	2.1.2. Философийн түүхийн судалгаа хийх.		
	2.1.3. Шинжлэх ухааны философийн судалгаа хийх.		
2.2. Монголын нийгэм, хөгжлийн философийн судалгаа хийх.	2.2.1. Монгол хүний ахуй, үнэлэмжийн философийн судалгаа хийх	+	+
	2.2.2. Монголын нийгмийн оюун санааны өөрчлөлт, хөгжлийн философийн суурь судалгаа хийх	+	+
	2.2.3. Монголын нийгмийн хөгжлийн өнөөгийн тулгамдсан асуудлаар суурь болон хавсарга судалгаа хийх.	+	+
	2.2.4. Монголын эдийн засгийн хөгжлийг хурдасгах, иргэдийн амьжиргааны түвшин, чанарыг дээшлүүлэх талаарх онол, арга зүйн үндэслэлийг боловсруулах.	+	+
2.3. Монголын философи сэтгэлгээний түүхийн судалгаа хийх.	2.3.1. Монголын философийн түүх, эх сурвалжийн судалгаа хийх.	+	+
	2.3.2. Монголын буддын сэтгэгчдийн төвөд хэлт бүтээлийн эрдэм шинжилгээний орчуулга, тайлбар хийх.	+	+
	2.3.3. Буддын философи, логик, танин мэдэхүйн онол, эх сурвалжийн судалгаа хийх.	+	+
2.4. Монголын нийгмийн болон сэтгэл зүйн өөрчлөлт, төлөв, хандлагыг судлах.	2.4.1. Нийгмийн бүтэц, давхраажилт, нийгмийн бүлгүүдийн хувирал, төлөвшлийг судлах.	+	+
	2.4.2. Нийгмийн оюун санааны амьдралд гарч буй хувьсал, өөрчлөлтийг судлах.	+	+
	2.4.3. Нийгмийн харилцаанд гарч буй өөрчлөлтийг талаар (нийгмийн ялгарал, капитал, тусгаарлагдах үйл явц гэх мэт) олон нийтийн санаа бодлын социологийн судалгаа хийх.	+	+

2.5. Ардчилал-засаглалын орчин үеийн хөгжлийн төлөв, хандлагын судалгаа хийх.	2.5.1. Ардчилал судлалын арга зүйн үндэслэлийг боловсруулах.	+	
	2.5.2. Монголын нийгмийн улс төрийн тогтолцоо, улс төрийн намын шинэчлэл, сонгуулийн тогтолцоо, улс төрийн амьдралын өөрчлөлт, хөгжлийн асуудлаар суурь болон хавсарга судалгаа хийх.	+	+
	2.5.3. Засаглал эрх мэдлийн харилцаан дахь улс төрийн хошуучлалын үүрэг, үр нөлөө, иргэдийн оролцооны орчныг судлах, суурь болон бодлогын судалгаа явуулах.	+	+
	2.5.4. Монголын ардчилал-засаглалын төлөв байдал, чиг хандлагыг тодорхойлсон дискурс анализын онолын болон эмпирик, хавсарга судалгаа хийх.		+
2.6. 1990-ээд оноос хойших Монголын улс төрийн тогтолцооны өөрчлөлтийг судлах.	2.6.1. Улс төрийн соёлын төлөвшил, хандлагын асуудлаар суурь судалгаа хийх.	+	+
	2.6.2.Монголын улс төрийн тогтолцоон дахь төрийн эрх мэдлийн хуваарилалт, тэнцвэржилт, төлөвшлийн тулгамдсан асуудал болон улс төрийн сэтгэлгээний түүхээр суурь судалгаа хийх.		+
	2.6.3. Монгол дахь улс төр, хууль зүйн шинжлэх ухааны суурь болон хавсарга судалгааны үр дүн: өнгөрсөн, одоо, ирээдүйн хөгжлийн төлөв, хавсарга судалгаа хийх.		
	2.6.4.Үндэсний хөгжлийн бодлого, төлөвлөлт, хэрэгжилтэд хамаарал бүхий талуудын оролцооны талаар хавсарга судалгаа хийх.		
	2.6.5. Төрийн албан хаагчийн улс төрийн соёлын төлөвшлийн хавсарга судалгаа хийх.		
2.7. Үндсэн хуулийн эрх зүйн судалгаа хийх.	2.7.1. Монголчуудын ёс суртахуун-эрх зүйн ухамсрын түвшинг дээшлүүлэх үндэсний хөтөлбөр боловсруулах суурь судалгаа хийх.	+	
	2.7.2. Монгол Улс дахь эрх зүйн тогтолцооны өөрчлөлт, өнөөгийн төлөв байдлын суурь судалгаа хийх.		+
	2.7.3. 1992 оны Үндсэн хуулийн үзэл баримтлалд тусгагдсан төлөөллийн ардчиллын эрх зүйн суурь зарчмуудад шинжилгээ хийх:	+	
2.8. Монгол дахь шашин шүтлэгийн төлөв, хандлагыг судлах.	2.8.1. Шашны философи, сэтгэл зүйн судалгаа хийх.		+
	2.8.2. Монголчуудын уламжлалт шашин, сүсэг бишрэлийн хандлага, төлөв байдлын судалгаа хийх.	+	+
	2.8.3. Монгол Улсын соёл иргэншлийн аюулгүй байдал ба шашин шүтлэгийн төлөв байдлын судалгаа хийх.		+
III стратеги зорилт: Хүний нөөцийн чадавхыг дээшлүүлэх			
3.1. Ажилтнуудыг эрдмийн зэрэг хамгаалах, мэргэжил дээшлүүлэх сургалтад хамрагдахыг дэмжих.	3.1.1.Эрдэм шинжилгээний ажилтныг гадаад, дотоодын их дээд сургуульд докторантурт суралцах, урт, богино хугацааны мэргэжил дээшлүүлэх сургалтад хамрагдахад дотоод журамд заасны дагуу дэмжлэг үзүүлэх.	+	+
	3.1.2. Хөдөлмөрийн эрүүл ахуй, аюулгүй байдал, хувь хүний хөгжлийн сургалтад хамруулах.	+	+
	3.1.3. Эрдмийн зэрэгтэй ажилтны тоог 30 хувиар нэмэгдүүлэх.	+	+
3.2. Судалгааны онол, арга зүйг эзэмших, мэдлэг, мэдээлэл, туршлага солилцох нөхцөлийг бүрдүүлэх.	3.2.1. Гадаадын эрдэм шинжилгээний байгууллага, их сургуулиудад ажиллаж буй эрдэмтдийг хүрээлэнд хэрэгжүүлж буй төсөлд хамрагдахыг дэмжих.	+	+
	3.2.2. Шинжлэх ухааны салбар дундын судалгааг хөгжүүлэхэд чиглэгдсэн эрдэмтдийн хамтын ажиллагааг дэмжих.	+	+
	3.2.3. Шинжлэх ухааны орчин үеийн хөгжлийн дэлхийн жишиг, хандлагад нийцсэн онол, арга зүйн тэргүүний ололтыг нэвтрүүлнэ.	+	+
	3.2.4. Эрдэм шинжилгээний ажилтнуудын бүтээлийн чанарыг сайжруулж, импакт фактор бүхий сэтгүүлд нийтлүүлэх тоог нэмэгдүүлэх	+	+

3.3. Гадаад, дотоодын байгууллагын төсөл, хөтөлбөрт оролцохыг дэмжих.	3.3.1. Олон улсын болон өөрийн орны шинжлэх ухааны сүлжээн дэх ажилтнуудын идэвх, санаачилгыг хөхиүлэн дэмжих.	+	+
IV стратеги зорилт: Судалгаа хөгжүүлэлтийн ажил эрхлэх таатай орчин бүрдүүлэх			
4.1. Хүрээлэнгийн мэдээллийн төвийг үйл ажиллагааг сайжруулах.	4.1.1. Төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэх, онол, арга зүйн мэдлэгээ гүнзгийрүүлэхэд шаардлагатай онолын судалгааны цахим болон хэвлэмэл ном бүтээлээр хангах.	+	+
4.2. Хүрээлэнгийн эрдэм шинжилгээний бүтээлийн цахим сан үүсгэх.	4.2.1. Хүрээлэнгийн цахим санг бий болгох журмыг боловсруулж, санхүүжилтийн эх үүсвэрийг бүрдүүлэх.		+
	4.2.2. Цаг хугацаа, орон зайнаас үл хамааран хүрээлэнгийн эрдэмтдийн бүтээл, эрдэм шинжилгээний цуврал бичиг, судалгааны тайлангийн цахим сан, мэдээллийн бааз бий болгох.		+
4.3. Тоон болон чанарын судалгааны шинэ программ хангамжуудыг ашиглах.	4.3.1. Социологи, нийгмийн сэтгэл зүй, улс төр судлал, эрх зүйн судалгаа хөгжүүлэлтийн ажилд хиймэл оюун ухааны хөгжлийн ололтод суурилсан программ хангамжийг ашиглах.	+	+
V стратеги зорилт: Гадаад харилцаа, хамтын ажиллагааг өргөжүүлэх			
5.1. Олон улсын болон гадаадын байгууллагатай хамтарсан төслийн тоог нэмэгдүүлэх.	5.1.1. Олон улсын болон гадаадтай хамтарсан төсөл хэрэгжүүлэхийг дэмжих, үр дүнгийн урамшуулал олгох.	+	+
5.2. Олон улсын болон бүс нутгийн мэргэжлийн холбоо, нийгэмлэг, байгууллагад гишүүнээр элсэж, үйл ажиллагаагаа өргөжүүлэх.	5.2.1. Хүрээлэнгийн салбарууд, эрдэм шинжилгээний ажилтнуудын санаачилгаар мэргэжлийн холбоо, нийгэмлэгт гишүүнээр элсэж, үйл ажиллагаанд нь идэвхтэй оролцох.	+	+
5.3. Гадаадын байгууллагуудтай хамтарсан судалгааг өргөжүүлж, харилцан мэдээлэл, туршлага солилцох.	5.3.1. Гадаад хамтын ажиллагааны гэрээ байгуулж, эрдэмтэн солилцооны хөтөлбөр хэрэгжүүлэх.	+	+
VI стратеги зорилт: Судалгааны үр дүнг нийгэмд түгээн дэлгэрүүлэх, нийгмийг соён гэгээрүүлэхэд дэмжлэг үзүүлэх			
6.1. Судалгааны үр дүнг хялбаршуулан таниулах замаар хэрэглээнд нэвтрүүлэх.	6.1.1. Хүүхэд, залуучуудын шинжлэх ухааны сэтгэлгээг төлөвшүүлэх зорилтыг холбогдох их дээд сургуулиуд, ЕБС болон бусад байгууллагатай хамтран хэрэгжүүлэх.	+	+
6.2. Судалгааны үр дүнг сургалт, судалгаа, хэрэглээний эргэлтэд оруулах.	6.2.1. Олон улсын нээлттэй шинжлэх ухааны уриалга, зарчмын дагуу судалгааны үр дүн болсон шинэ мэдлэг, зөвлөмж, өгөгдлийг шийдвэр гаргагчид, олон нийт, аж ахуйн нэгжид нээлттэй хүртээмжтэй түгээх.	+	+
6.3. Хүрээлэнгийн эрдэм шинжилгээ, үйл ажиллагааны талаарх мэдээ, мэдээллийг сурталчлан таниулах.	6.3.1. Хүрээлэнгийн эрдэм шинжилгээ, үйл ажиллагааны талаарх мэдээ, мэдээллийг ОНМХ, нийгмийн сүлжээгээр тогтмол мэдээлэх.	+	+
	6.3.2. Хүрээлэнгийн вэб сайтыг хөгжүүлж, хандалт, хэрэглэгчдийн тоог нэмэгдүүлэх.	+	+
	6.3.3. Олон улсын болон үндэсний хэмжээний шинжлэх ухаан, технологийн үзэсгэлэнгүүдэд тогтмол оролцох.	+	+

Тав. СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨ ХЭРЭГЖҮҮЛЭГЧДИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ УЯЛДАА ХОЛБОО

Үйл ажиллагааны зорилтууд	Хэрэгжүүлэгч нэгж					
	Захиргаа, аж ахуй	Философийн салбар -Улс төрийн эдийн засгийн тасаг	Социологи, нийгмийн сэтгэл зүйн салбар	Улс төр, эрх зүйн салбар	Шашин судлалын салбар	Баян-Өлгий аймаг дахь салбар
I стратеги зорилт: Хүрээлэнгийн менежментийн чадавхыг бэхжүүлэх						
1.1. Хүрээлэнгийн үйл ажиллагааны төлөвлөлт, зохион байгуулалт, хяналтын тогтолцоог сайжруулах.						
1.2. Хүрээлэнгийн үйл ажиллагааны санхүүжилтийн эх үүсвэрийг нэмэгдүүлэх.						
1.3. Эрдэм шинжилгээний тэргүүлэх чиглэлийг шинэчлэн тодорхойлох.						
1.4. Их дээд сургууль, төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтын ажиллагааг өргөжүүлэх.						
Монгол Улсад философи, социологи, улс төр судлал, улс төрийн эдийн засаг, эрх зүй, шашин судлалын суурь судалгааг хөгжүүлэх II стратеги зорилт: Онолын судалгааны түвшинг дээшлүүлж, шинэ мэдлэг бий болгох						
2.1. Философийн онол, түүхийн судалгаа хийх						
2.2. Монголын нийгэм, хөгжлийн философийн судалгаа хийх						
2.3. Монголын философи сэтгэлгээний түүхийн судалгаа хийх.						
2.4. Монголын нийгмийн болон сэтгэл зүйн өөрчлөлт, төлөв, хандлагыг судлах.						
2.5. Ардчилал-засаглалын орчин үеийн хөгжлийн төлөв, хандлагыг судлах.						
2.6. 1990-ээд оноос хойших Монголын улс төрийн тогтолцооны өөрчлөлтийг судлах.						
2.7. Үндсэн хуулийн эрх зүйн судалгаа хийх.						
2.8. Монгол дахь шашин шүтлэгийн төлөв, хандлагыг судлах.						
III стратеги зорилт: Хүний нөөцийн чадавхыг дээшлүүлэх						
3.1. Ажилтнуудыг эрдмийн зэрэг хамгаалах, мэргэжил дээшлүүлэх сургалтад хамрагдахыг дэмжих.						
3.2. Судалгааны онол, арга зүйг эзэмших, мэдлэг, мэдээлэл, туршлага солилцох нөхцөлийг бүрдүүлэх.						
3.3. Гадаад, дотоодын байгууллагын төсөл, хөтөлбөрт оролцохыг дэмжих.						
IV стратеги зорилт: Судалгаа хөгжүүлэлтийн ажил эрхлэх таатай орчин бүрдүүлэх						
4.1. Хүрээлэнгийн мэдээллийн төвийг үйл ажиллагааг сайжруулах.						
4.2. Хүрээлэнгийн эрдэм шинжилгээний бүтээлийн цахим сан үүсгэх.						
4.3. Тоон болон ча.нарын судалгааны шинэ программ хангамжуудыг ашиглах.						
V стратеги зорилт: Гадаад харилцаа, хамтын ажиллагааг өргөжүүлэх						
5.1. Олон улсын болон гадаадын байгууллагатай хамтарсан төслийн тоог нэмэгдүүлэх.						
5.2. Олон улсын болон бүс нутгийн мэргэжлийн холбоо, нийгэмлэг, байгууллагад гишүүнээр элсэж, үйл ажиллагаагаа өргөжүүлэх.						

5.3. Гадаадын байгууллагуудтай хамтарсан судалгааг өргөжүүлж, харилцан мэдээлэл, туршлага солилцох.						
VI стратеги зорилт: Судалгааны үр дүнг нийгэмд түгээн дэлгэрүүлэх, нийгмийг соён гэгээрүүлэхэд дэмжлэг үзүүлэх						
6.1. Судалгааны үр дүнг хялбаршуулан таниулах замаар хэрэглээнд нэвтрүүлэх.						
6.2. Судалгааны үр дүнг сургалт, судалгаа, хэрэглээний эргэлтэд оруулах.						
6.3. Хүрээлэнгийн эрдэм шинжилгээ, үйл ажиллагааны талаарх мэдээ, мэдээллийг сурталчлан таниулах.						

Зургаа. СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨ ХЭРЭГЖҮҮЛЭХЭД ШААРДЛАГАТАЙ ХӨРӨНГӨ, САНХҮҮЖИЛТИЙН ЭХ ҮҮСВЭР

№	Үйл ажиллагааны зорилтууд	Шаардагдах хөрөнгийн хэмжээ (сая төг.)	Үүнээс санхүүжилтийн эх үүсвэр (%)			
			Улсын төсөв	Гадаадын төсөл, хөтөлбөр	Судалгаа, гэрээт ажлын орлого	Бусад
Стратегийн зорилт I. **Хүрээлэнгийн менежментийн чадавхыг бэхжүүлэх**						
1.1	Хүрээлэнгийн үйл ажиллагааны төлөвлөлт, зохион байгуулалт, хяналтын тогтолцоог сайжруулах.	5.0	100%	-	-	-
1.2	Хүрээлэнгийн үйл ажиллагааны санхүүжилтийн эх үүсвэрийг нэмэгдүүлэх.	10.0	85%	5%	10%	-
1.3	Эрдэм шинжилгээний тэргүүлэх чиглэлийг шинэчлэн тодорхойлох.	-	-	-	-	-
1.4	Их дээд сургууль, төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтын ажиллагааг өргөжүүлэх.	24.0	50%	-	-	50%
	Дэд дүн	**39.0**				
Стратегийн зорилт II. **Онолын судалгааны түвшинг дээшлүүлж, шинэ мэдлэг бий болгох**						
2.1	Философийн онол, түүхийн судалгаа хийх	60.0	80%	-	20%	-
2.2	Монголын нийгэм, хөгжлийн философийн судалгаа хийх.	30.0	80%	-	-	20%
2.3	Монголын философи сэтгэлгээний түүхийн судалгаа хийх.	10.0	80%	-	20%	-
2.4	Монголын нийгмийн болон сэтгэл зүйн өөрчлөлт, төлөв, хандлагыг судлах.	70.0	80%	20%	-	-
2.5.	Ардчилал-засаглалын орчин үеийн хөгжлийн төлөв, хандлагыг судлах.	70.0	80%	20%	-	-
2.6.	1990-ээд оноос хойших Монголын улс төрийн тогтолцооны өөрчлөлтийг судлах.	70.0	80%	20%	-	-
2.7.	Үндсэн хуулийн эрх зүйн судалгаа хийх.	150.0	100%	-	-	-
2.8.	Монгол дахь шашин шүтлэгийн төлөв, хандлагыг судлах.	50.0	80%	20%	-	-
	Дэд дүн	**530.0**				
Стратегийн зорилт III. **Хүний нөөцийн чадавхыг дээшлүүлэх**						
3.1.	Ажилтнуудыг эрдмийн зэрэг хамгаалах, мэргэжил дээшлүүлэх сургалтад хамрагдахыг дэмжих.	5.0	40%	20%	-	20%
3.2.	Судалгааны онол, арга зүйг эзэмших, мэдлэг, мэдээлэл, туршлага солилцох нөхцөлийг бүрдүүлэх.	3.0	70%	20%	-	10%
3.3.	Гадаад, дотоодын байгууллагын төсөл,	10.0	-	100%	-	-

	хөтөлбөрт оролцохыг дэмжих.					
	Дэд дүн	**18.0**				
	Стратегийн зорилт IV. **Судалгаа хөгжүүлэлтийн ажил эрхлэх таатай орчин бүрдүүлэх**					
4.1.	Хүрээлэнгийн мэдээллийн төвийг үйл ажиллагааг сайжруулах.	10.0	70%	-	-	30%
4.2.	Хүрээлэнгийн эрдэм шинжилгээний бүтээлийн цахим сан үүсгэх.	15.0	70%	-	30%	-
4.3.	Тоон болон чанарын судалгааны шинэ программ хангамжуудыг ашиглах.	10.0	60%	20%	20%	-
	Дэд дүн	**35.0**				
	Стратегийн зорилт V. **Гадаад харилцаа, хамтын ажиллагааг өргөжүүлэх**					
5.1.	Олон улсын болон гадаадын байгууллагатай хамтарсан төслийн тоог нэмэгдүүлэх.	20.0	70%	30%		
5.2.	Олон улсын болон бүс нутгийн мэргэжлийн холбоо, нийгэмлэг, байгууллагад гишүүнээр элсэж, үйл ажиллагаагаа өргөжүүлэх.	150.0	60%	40%	-	-
5.3.	Гадаадын байгууллагуудтай хамтарсан судалгааг өргөжүүлж, харилцан мэдээлэл, туршлага солилцох.	150.0	70%	30%	-	-
	Дэд дүн	**320.0**				
	Стратегийн зорилт VI. **Судалгааны үр дүнг нийгэмд түгээн дэлгэрүүлэх, нийгмийг соён гэгээрүүлэхэд дэмжлэг үзүүлэх**					
6.1.	Судалгааны үр дүнг хялбаршуулан таниулах замаар хэрэглээнд нэвтрүүлэх.	12.0	50%	20%	-	30%
6.2.	Судалгааны үр дүнг сургалт, эрдэм шинжилгээ, хэрэглээний эргэлтэд оруулах.	25.0	50%	30%	20%	-
6.3.	Хүрээлэнгийн эрдэм шинжилгээ, үйл ажиллагааны талаарх мэдээ, мэдээллийг сурталчлан таниулах.	100.0	50%	20%	-	30%
	Дэд дүн	**137.0**				
	Нийт дүн	**1079.0**				

Долоо. СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ЗАМ

7.1. Эрдэм шинжилгээний ажилтныг чадавхыг бэхжүүлэх

1. Ахмад-дунд-залуу үеийн залгамж холбоог бэхжүүлэх, мэдлэг, туршлагаас солилцох нөхцөлийг бүрдүүлэх.
2. Эрдэм шинжилгээний ажилтнаар ажиллуулах иргэнийг сонгон шалгаруулах журмыг дагаж мөрдөх.
3. Эрдэм шинжилгээний залуу ажилтныг гадаад улсад мэргэжил дээшлүүлэхэд санхүүгийн дэмжлэг үзүүлэх.
4. Эрдэм шинжилгээний ажилтныг шинэ мэдээллээр хангах, дадлагажуулах, тэднийг эрдэм шинжилгээний ажлын арга барилд сургах чиглэлээр ажиллах.
5. Олон улсын өндөр зэрэглэлтэй сэтгүүлд эрдэм шинжилгээний өгүүлэл хэвлүүлэх аргачлалын талаар сургалт явуулах.
6. Гадаадад ажиллаж буй судлаачдыг хүрээлэнгийн төсөлд татан оролцуулах боломж бүрдүүлэх.
7. Шинжлэх ухааны докторын (Sc.D) зэрэг хамгаалсан эрдэм шинжилгээний ажилтны тоог нэмэгдүүлэх.

№	Эрдмийн зэрэг, цол	Хүрэх түвшин	Үүнээс		
			2017-2021	2022-2025	ШУ-ны салбар тус бүрээр
1	Академич	**2**		2	Философи
					Эдийн засаг
2	Доктор (Sc.D)	**4**	1	1	Философи
				1	Улс төрийн шинжлэх ухаан
			1		Эдийн засаг
3	Доктор (Ph.D)	**8**	1	1	Философи
			1	2	Социологи
				2	Шашин судлал
			1		Улс төр судлал

7.2. Судалгаа хөгжүүлэлтийн ажлын менежментийн оновчлол

1. Хүрээлэнд хийгдэх онолын суурь ба хавсарга судалгаанд санхүүгийн нэмэлт эх үүсвэр бүрдүүлэх, судалгааны ажлын материаллаг бааз, техник хэрэгслийн хангамжийг сайжруулах талаар идэвх санаачилгатай ажиллах.
2. Хүрээлэнгийн эрдэм шинжилгээний тэргүүлэх чиглэлийн хүрээнд төрийн болон төрийн бус байгууллага, хувийн хэвшилтэй хамтран ажиллана.
3. Хүрээлэнгийн ажлын өрөөний дутагдлыг арилгаж ажилтныг хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлага хангана.
4. Салбарууд эрдэм шинжилгээний ажилтнуудын судалгааны чиглэлтэй уялдуулан олон улсын жишиг, хандлагад нийцүүлсэн төсөл хэрэгжүүлнэ.
5. Хүрээлэнд хэрэгжүүлэх төслийн сахилга батыг сайжруулна.

7.3. Гадаад хамтын ажиллагааны нөөц боломжийг ашиглах

1. Олон улсын болон гадаадын байгууллагатай хамтарсан төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх гэрээ хэлэлцээр байгуулна.
2. Хамтарсан судалгааны баг байгуулах, эрдэмтэн солилцоо, зочин судлаачийн хөтөлбөрийг дэмжинэ.
3. Гадаадтай хамтарсан төслийн тоог нэмэгдүүлэх, үр дүнг түгээн дэлгэрүүлэх, хамтын ажиллагааны үр өгөөжийг нэмэгдүүлэхэд онцгойлон анхаарч ажиллана.

7.4. Үйл ажиллагааны төлөвлөлт, гүйцэтгэлийн хариуцлагыг сайжруулах

1. Хүрээлэн жил бүр эрдэм шинжилгээ, үйл ажиллагааны нэгдсэн төлөвлөгөөг боловсруулан, эрдмийн зөвлөлөөр хэлэлцэн батлуулна.
2. Эрдэм шинжилгээ, үйл ажиллагааны нэгдсэн төлөвлөгөөний хэрэгжилтийг улирал, хагас жилийн ажлын тайлангаар нэгтгэн дүгнэж үнэлгээ өгнө.
3. Стратеги төлөвлөгөөний гүйцэтгэлийн тайланг 2020, 2024 онд нэгтгэн, цаашид сайжруулах, шинээр санаачлан хийх ажлыг хамтын хэлэлцүүлэг шийдвэрийн дагуу боловсруулж ажиллана.

7.5. Нийгмийн хөгжилд үзүүлэх үр нөлөөг дээшлүүлэх

1. Монголын нийгмийн хөгжлийн бодлогыг боловсруулахад шаардлагатай үзэл баримтлал, арга зүйн үндэслэл гаргаж дэвшүүлэх, зөвлөмж гаргах ажлыг нэмэгдүүлсэн байна.
2. Нийгэмд шинжлэх ухааны мэдлэгийг түгээн дэлгэрүүлэхэд хувь нэмэр оруулна.
3. Монголын нийгэм, оюун санааны амьдралын тулгамдсан асуудлаарх хавсарга, захиалгат судалгааны үр дүнг ХМХ-ээр танилцуулна.
4. Хууль, бодлогын баримт бичгийн төсөлд зөвлөмж, санал боловсруулж холбогдох байгууллагад хүргэнэ.
5. Нийгэм, хүмүүнлэгийн ухааны сурах бичиг, гарын авлага бичиж хэвлүүлнэ.

Найм. СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

№	Стратеги төлөвлөгөөний үйл ажиллагааны зорилтууд	Хэрэгжилтийн шалгуур үзүүлэлтүүд	Хэмжих нэгж	Суурь түвшин (2017)	Хүрэх түвшин	
					I үе шат	II үе шат
Нэг. Хүрээлэнгийн менежментийн чадавхыг бэхжүүлэх						
1.1	Хүрээлэнгийн үйл ажиллагааны төлөвлөлт, зохион байгуулалт, хяналтын тогтолцоог сайжруулах.	Зохион байгуулалтын оновчтой хэлбэр, хяналтын тогтолцоо сайжирсан байдал	%	85	95	100
1.2	Хүрээлэнгийн үйл ажиллагааны санхүүжилтийн эх үүсвэрийг нэмэгдүүлэх.	Санхүүжилтийн эх үүсвэрийн тоо, түүний өсөлт	%	30	50	70
1.3	Эрдэм шинжилгээний тэргүүлэх чиглэлийг шинэчлэн тодорхойлох.	Тэргүүлэх чиглэлээр хэрэгжсэн төсөл	тоо	3	4	6
		Захиалгат төсөл	тоо	2	2	3
1.4	Их дээд сургууль, төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтын ажиллагааг өргөжүүлэх.	Хамтран зохион байгуулсан сургалт, ЭШБХ, хэрэгжүүлсэн төсөл	тоо	4	5	7
Хоёр. Онолын судалгааны түвшинг дээшлүүлж, шинэ мэдлэг бий болгох						
2.1	Философийн онол, түүхийн судалгаа хийх	Орчуулгын бүтээл, нэг сэдэвт бүтээл	тоо	Тодорхой түвшний судалгаа хийгдсэн.	8	9
2.2	Монголын нийгэм, хөгжлийн философийн судалгаа хийх.	Орчуулгын бүтээл, нэг сэдэвт бүтээл, зөвлөмж	тоо	Тодорхой түвшний судалгаа хийгдсэн.	5	7
2.3	Монголын философи сэтгэлгээний түүхийн судалгаа хийх.	Орчуулгын бүтээл, нэг сэдэвт бүтээл, өгүүлэл	тоо	Тодорхой түвшний судалгаа хийгдсэн.	4	3
2.4	Монголын нийгмийн болон сэтгэл зүйн өөрчлөлт, төлөв, хандлагыг судлах.	Нэг сэдэвт болон хамтын бүтээл, Боловсруулсан судалгааны тайлан	тоо	Тодорхой түвшний судалгаа хийгдсэн.	6	9
2.5.	Ардчилал-засаглалын орчин үеийн хөгжлийн төлөв, хандлагыг судлах.	Орчуулгын бүтээл, нэг сэдэвт бүтээл	тоо	Тодорхой түвшний судалгаа хийгдсэн.	6	6
2.6.	1990-ээд оноос хойших Монголын улс төрийн тогтолцооны өөрчлөлтийг судлах.	Орчуулгын бүтээл, нэг сэдэвт бүтээл, зөвлөмж	тоо	Тодорхой түвшний судалгаа хийгдсэн	6	6
2.7.	Үндсэн хуулийн эрх зүйн судалгаа хийх.	Зөвлөмж, хамтын бүтээл, өгүүлэл	тоо	Тодорхой түвшний судалгаа хийгдсэн	7	12
2.8.	Монгол дахь шашин шүтлэгийн төлөв, хандлагыг судлах.	Өгүүлэл, хамтын бүтээл, зөвлөмж, судалгааны тайлан.	тоо	Тодорхой түвшний судалгаа хийгдсэн.	42	45
Гурав. Хүний нөөцийн чадавхыг дээшлүүлэх						

3.1.	Ажилтнуудыг эрдмийн зэрэг хамгаалах, мэргэжил дээшлүүлэх сургалтад хамрагдахыг дэмжих.	ЭША-ы тоо	тоо	45	45	50
		Мэргэжил дээшлүүлсэн сургалтанд хамрагдсан ажилтан	тоо	3	10	11
		Доктор болон түүнээс дээш зэрэгтэй ЭША	%	30.6%	38.6%	60%
3.2.	Судалгааны онол, арга зүйг эзэмших, мэдлэг, мэдээлэл, туршлага солилцох нөхцөлийг бүрдүүлэх.	Олон улсын болон үндэсний судалгааны грант бүхий төсөл удирддаг эрдэмтэн	тоо	2/5	5/7	6/12
3.3.	Гадаад, дотоодын байгууллагын төсөл, хөтөлбөрт оролцохыг дэмжих.	Төсөл, хөтөлбөрт оролцсон эрдэмтэд	тоо	3/5	3/3	4/6
Дөрөв. Судалгаа хөгжүүлэлтийн ажил эрхлэх таатай орчин бүрдүүлэх						
4.1.	Хүрээлэнгийн мэдээллийн төвийг үйл ажиллагааг сайжруулах.	ЭША-ы үйлчлүүлсэн ном бүтээлийн тоо	тоо	455	480	560
4.2.	Хүрээлэнгийн эрдэм шинжилгээний бүтээлийн цахим сан үүсгэх.		%	0	10%	60%
4.3.	Тоон болон чанарын судалгааны шинэ программ хангамжуудыг ашиглах.	Социологи, эрх зүйн салбарт программуудыг ашигласан байна.	тоо	1/1	2/3	3/3
Тав. Гадаад харилцаа, хамтын ажиллагааг өргөжүүлэх						
5.1.	Олон улсын болон гадаадын байгууллагатай хамтарсан төслийн тоог нэмэгдүүлэх.	Хамтарсан төсөл хэрэгжүүлсэн байна.	тоо	1	3	4
5.2.	Олон улсын болон бүс нутгийн мэргэжлийн холбоо, нийгэмлэг, байгууллагад гишүүнээр элсэж, үйл ажиллагаагаа өргөжүүлэх.	ЭША, удирлагын санаачилгаар элссэн байна.	тоо	1	2	3
5.3.	Гадаадын байгууллагуудтай хамтарсан судалгааг өргөжүүлж, харилцан мэдээлэл, туршлага солилцох.	Эрдэмтэн солилцооны тоо	тоо	2	2	5
		Гэрээ, хэлэлцээрийн тоо	тоо	5	7	10
Зургаа. Судалгааны үр дүнг нийгэмд түгээн дэлгэрүүлэх, нийгмийг соён гэгээрүүлэхэд дэмжлэг үзүүлэх						
6.1.	Судалгааны үр дүнг хялбаршуулан таниулах замаар хэрэглээнд нэвтрүүлэх.	Эрдэмтэд, ЭША-ы хэвлүүлсэн сурах бичиг, гарын авлага, зургийн цомог	тоо	3	6	8
6.2.	Судалгааны үр дүнг сургалт, судалгаа, хэрэглээний эргэлтэд оруулах.	Цуврал лекцийн тоо	тоо	4	9	13
6.3.	Хүрээлэнгийн эрдэм шинжилгээ, үйл ажиллагааны талаарх	ХМХ-ээр түгээсэн ярилцлага, мэдээллийн тоо	тоо	18	76	126

	мэдээ, мэдээллийг сурталчлан таниулах.	Хүрээлэнгийн сайтад хандагчдын тоо	тоо	500	5600	20000

Ес. СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ УДИРДЛАГА, ҮНЭЛГЭЭ

ШУА-ийн Философийн хүрээлэнгийн эрдэм шинжилгээ, үйл ажиллагааны урт болон дунд, богино хугацааны стратегийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх, түүний хэрэгжилтэд хяналт тавих, гүйцэтгэлийг тооцон ажиллахын тулд дараах алхмуудыг авч хэрэгжүүлнэ.

9.1. Стратеги төлөвлөгөөний удирдлага, зохион байгуулалт

- Хүрээлэнгийн стратеги төлөвлөгөөг хэрэгжүүлэх ажлыг удирдан зохион байгуулах, зохицуулах, хяналт тавих үүргийг ШУА-ийн Тэргүүлэгчдийн газрын дэргэдэх “Стратеги удирдлагын зөвлөл”-ийн зөвлөл (цаашид Зөвлөл гэх) гүйцэтгэнэ.
- Хүрээлэнгийн эрдмийн зөвлөлийн хурлаар стратеги төлөвлөгөөний гүйцэтгэлийн тайланг хэлэлцэж дүгнэлт гаргана.
- Хүрээлэнгийн захиргаа Стратеги төлөвлөгөөний зорилт, арга хэмжээнүүдийг хүрээлэн, салбарын жил бүрийн төлөвлөгөө, төсөвт тусгах, хэрэгжилтийг удирдан зохицуулах, явцад нь хяналт тавих, биелэлтийг дүгнэж, тайлагнах, санхүүгийн болон бусад нөөцийг зохистой хуваарилах талаар санал, шийдвэрийн төсөл боловсруулж хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулна.
- Стратеги төлөвлөгөөний хүрээнд гүйцэтгэсэн жилийн ажлын гол үр дүнг нэгтгэж, хүрээлэнгийн тайланд тусгаж, эрдмийн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлнэ.

9.2. Стратеги төлөвлөгөөний хэрэгжилтийн үнэлгээ

- Стратеги төлөвлөгөөний шалгуур үзүүлэлт бүрийн хэрэгжилтийн явцыг оны эцэст суурь түвшин (2017)-тэй харьцуулан дүгнэнэ.
- Салбарууд Стратеги төлөвлөгөөнд тусгагдсан зорилт, арга хэмжээнүүдээс хэрэгжихгүй байгаа эсвэл дутуу хэрэгжиж буй ажлын явц, шалтгаанд үнэлгээ өгч, авах арга хэмжээний санал боловсруулж хүрээлэнгийн Захиргааны зөвлөл болон Эрдмийн зөвлөлд танилцуулна.

Хүснэгт 1. Хүрээлэнгийн эрдэм шинжилгээ, үйл ажиллагааны
хэтийн төлөвлөлтийн матриц

Төрөл	Богино хугацаа	Дунд хугацаа	Урт хугацаа
Хугацаа (жилээр)	**1 жил (2017-2018)**	**1-4 жил (2019-2021)**	**4-8 жил (2022-2025)**
Зорилго, зорилт	**SMART**	**SMART**	**Ерөнхий**
Тэргүүлэх чиглэл	Шаардлагатай	Тэргүүлэх чиглэл тодорхойлно	Тэргүүлэх чиглэл байна
Нөхцөл байдал, техник шинжилгээ	Нэн ойрын ирээдүйд шаардлагатай	Тухайлсан	Ерөнхий
Стратеги, эх үүсвэр	Нэн ойрын ирээдүйн төлөвлөгөөг дэлгэрэнгүй гаргах	Тухайлсан болон мэргэшүүлсэн төлөвлөгөөг боловсруулах	Дараагийн 8 жилийн төлөвлөгөөг боловсруулах
Үе шаттай эсэх	Ойрын ирээдүйн дүр зургыг гаргах	Үе шаттай хэрэгжүүлж, дүгнэх	Үе шаттай хэрэгжүүлж, дүгнэх
Зардалтай эсэх	Шаардлагатай төсвийн төсөөлөл гаргаж, үйл ажиллагаатай уялдуулах	Шаардлагатай төсвийг үйл ажиллагаатай уялдуулан тооцох	Шаардлагатай төсвийн тооцоо гаргах
Хянах боломж	Үр нөлөө, үр дүнг хянах боломжтой	Үр нөлөө, үр дүнг хянах боломжтой	Үр нөлөөг хянах боломжтой, хэтийн зорилтыг төсөөлөх
Хариуцах эзэн	Захирал, ЭНБД, Салбарын эрхлэгч, ЭША-нууд	Захирал, ЭНБД, Салбарын эрхлэгч, ЭША-нууд	Захирал, ЭНБД, Салбарын эрхлэгч, ЭША-нууд

Хууль зүйн үндэслэл	УИХ, Засгийн газар, салбарын яам, дээд шатны байгууллагын дүрэм журамд нийцүүлэх	УИХ, ЗГ, салбарын яам, дээд шатны байгууллагын дүрэм журамд нийцүүлэх	УИХ, Засгийн газар, салбарын яам, дээд шатны байгууллагын дүрэм журамд нийцүүлэх

Хүрээлэнгийн урт хугацааны стратегийн төлөвлөгөөний зорилтыг 8 жилийн хугацаатай ерөнхий байдлаар бичиж, шалгуур үзүүлэлтийн хэмжих нэгжийг хувь, тоогоор илэрхийлсэн бөгөөд хяналт, үнэлгээ явуулахад шаардагдах эх үүсвэрийг төсөөллийн байдлаар төлөвлөсөн болно.

Хүрээлэнгийн стратегийн төлөвлөгөөний зорилтыг тодорхойлоход дараах зарчмуудыг (SMART) баримталсан. Үүнд:

1) *Тодорхой байх - sustainability* (тулгамдсан асуудлыг шийдэхэд чиглэгдсэн, ямар арга замаар гэдэг нь тодорхой байх)
2) *Хэмжих боломжтой байх -measurable* (аль болох тоогоор илэрхийлэх)
3) *Зохистой-appropriate* (гарч болзошгүй үр нөлөө ялангуяа бусад салбарт үзүүлэх үр дагаврыг тооцсон, хуулийн дагуу байх)
4) *Бодитой - reliability* (хэрэгжих боломжтой байх)
5) *Цаг хугацаатай байх-time able* зэрэг болно.

Хавсралт 1.

ХҮРЭЭЛЭНГИЙН ТҮҮХЭН ХӨГЖИЛ, БҮТЭЦ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

Тус улсын философи, нийгэм, улс төрийн сэтгэлгээг хөгжүүлэх зорилгоор МАХН-ын Төв хорооны 1972 оны 7 дугаар сарын 15-ны өдрийн 193 тоот тогтоолоор[1] «Философи, социологи, эрхийн хүрээлэн» нэртэйгээр анх байгуулж, үйл ажиллагааны үндсэн чиглэлийг нь тодорхойлон заажээ. Тус хүрээлэн байгуулагдсан цагаасаа хойш өрнө, дорнын философи, монголын философи болон нийгэм-улс төрийн сэтгэлгээний түүх, социологи, улс төр судлал, шашин судлал, Үндсэн хуулийн эрх зүйн чиглэлээр онолын судалгаа явуулж байна.


Монголын гүн ухаан, нийгэм улс-төр, эрхийн сэтгэлгээний түүхийн чиглэлээр мэргэжлийн түвшинд судалгаа хийх эрдэм шинжилгээний байгууллага ШУА-ийн Түүхийн хүрээлэнд “Гүн ухаан, хууль цааз судлалын тасаг” нэртэй 1967 онд, “Буддын судлалын сектор” 1969 онд байгуулагджээ. Философи, социологи, эрхийн хүрээлэн байгуулах шийдвэрт Философи, Социологи, Төр эрхийн хэлтэсүүдтэй байгуулахыг заасан.

1980-аад оны дундуур философийн, социологийн, төр эрхийн, шинжлэх ухааны социализмын онолын, буддын судлалын, шинжлэх ухаан судлалын 6 сектортой 60 гаруй эрдэм шинжилгээний ажилтнуудтай үйл ажиллагаагаа явуулах болсон байв. Тус хүрээлэн манай нийгмийн өнгөрсөн ба тухайн үеийн шаардлагатай чухал асуудлуудад онол, практикийн санал, зөвлөмж, боловсруулан удирдах дээд байгууллага болон холбогдох газруудад хүргүүлж байсан. Мөн хүрээлэн бие дааж, бусад газруудтай хамтарч өнгөрсөн хугацаанд өнөөгийн нийгмийн тулгамдсан чухал асуудлуудаар онол, арга зүйн эрдэм шинжилгээний хурлуудыг зохион байгуулж ирсэн.

Монгол Улсын Засгийн газрын 2015 оны 1 дүгээр сарын 26-ны өдрийн 27 тоот тогтоолоор Философийн хүрээлэн нэртэй болж, Баян-Өлгий аймаг дахь ШУА-ийн Нийгэм, эдийн засгийн бодлогын судалгааны төвийг нэгтгэн хүрээлэнгийн бүтцэд Шашин судлалын салбар, Нийгэм, эдийн засгийн бодлогын судалгааны салбарыг бий болгосон юм.

Хүрээлэнгийн шинэ бүтэц, зохион байгуулалтыг ШУА-ийн Тэргүүлэгчдийн 2017 оны 3 дугаар сарын 30-ны өдрийн хурлын 10 тоот тогтоолоор батлалсан болно (Зураг 1).

[1] МАХН-ын Төв хорооны Улс төрийн товчооны тогтоол. 1972 оны 7 дугаар сарын 15, Дугаар 193, Улаанбаатар хот.



Зураг 1. Хүрээлэнгийн бүтэц

Монгол Улсын Шинжлэх ухааны Академийн Философийн хүрээлэн нь 2017 оны байдлаар 5 салбар, захиргаа аж ахуйн нэгжтэй, нийт 50 ажилтантай үйл ажиллагаа явуулж байна. Үүнээс 45 нь эрдэм шинжилгээний ажилтан, 5 нь захиргааны ажилтан байна. Үүнээс тэргүүлэх ажилтан 5, ахлах ажилтан 4, дэд ажилтан 20, дадлагажигч ажилтан 5, ЭША 14 байна. Жилд дунджаар 557.224,0 мянган төгрөгийн санхүүжилтэй. Нийт санхүүжилтийн 458.791,0 мянган төгрөг буюу 82.3% нь цалинд зарцуулагддаг.

Философийн салбар: Тус салбар 11 эрдэм шинжилгээний ажилтантай, академич 1, ШУ-ны доктор (Sc.D) 3, доктор (Ph.D) 4, магистр 4, тэргүүлэх ажилтан 3, дундаж нас нь 51.8 байна. Жилд дунджаар 120.745.2 мянган төгрөгийн санхүүжилт авч, цалинд 107.967.6 мянган төгрөгийг, эрдэм шинжилгээний зардалд 12.777.6 мянган төгрөг зарцуулдаг.

Тус салбарт Улс төрийн эдийн засгийн ухааны тасаг нээгдэн 2018 оны 3 дугаар сараас ажиллаж байна. 1 ажилтантай.

Социологи, нийгмийн сэтгэл зүйн салбар: Тус салбар 8 эрдэм шинжилгээний ажилтантай, доктор (Ph.D) 2, магистр 6, тэргүүлэх ажилтан 1, дундаж нас нь 35.8 байна. Жилд дунджаар цалинд 68.943.7 мянган төгрөгийг зарцуулдаг.

Улс төр, эрх зүйн салбар: Тус салбар 13 эрдэм шинжилгээний ажилтантай, академич 1, доктор (Sc.D) 1, доктор (Ph.D) 4, магистр 6, ахлах ажилтан 1, дундаж нас нь 38.1 байна. Жилд дунджаар 137.960,0 мянган төгрөгийн санхүүжилт авч, цалинд 132.020,0 мянган төгрөгийг, эрдэм шинжилгээний зардалд 5.940.0 мянган төгрөг зарцуулдаг.

Шашин судлалын салбар: Тус салбар 5 эрдэм шинжилгээний ажилтантай, үүнээс доктор (Ph.D) 1, магистр 4, дундаж нас нь 41.6 байна. Жилд дунджаар 64.240.4 мянган төгрөгийн санхүүжилт авч, цалинд 50.092.6 мянган төгрөгийг, эрдэм шинжилгээний зардалд 14.147.8 мянган төгрөг зарцуулдаг.

Баян-Өлгий аймаг дахь салбар: Тус салбар 8 эрдэм шинжилгээний ажилтантай, үүнээс доктор (Ph.D) 1, магистр 6, тэргүүлэх ажилтан 1, дундаж нас нь 42.1 байна. Жилд дунджаар цалинд 66.631.9 мянган төгрөгийг зарцуулдаг.

Хавсралт 2.

ХҮРЭЭЛЭНГИЙН ХҮНИЙ НӨӨЦ

Хүрээлэнгийн хүний нөөцийн талаар авч хэрэгжүүлсэн бодлого, үйл ажиллагааг дараах байдлаар тайлагнаж байна.

2017 оны байдлаар хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтнуудын дундаж нас 39, доктор болон түүнээс дээш эрдмийн зэрэгтэй ажилтан эзлэх хувь 30.6 байгаа бөгөөд хүйсийн хувьд эрэгтэйчүүд 26, эмэгтэйчүүд 23 байгаа жендэрийн тэгш байдал 1:1.13 харьцаатай байв.

Хүснэгт 1. Эрдмийн болон боловсролын зэрэгтэй ЭША-нуудын нас

№	Эрдмийн зэрэг, цол	Тоо	Үүнээс			
			35 хүртэлх насны	35-50 насны	50-иас дээш насны	Дундаж нас
1	Академич	2			2	**62**
2	Доктор (Sc.D)	4			2	**57**
3	Доктор (Ph.D)	9	1	2	8	**47**
4	Магистр (үүнээс докторант 9)	28	17	10	1	**34.1**
5	Бакалавр	2	2			**27**

Харин 2020 оны 11 сарын байдлаар үндсэн ажилтан 50 (үүнээс 50 хувийн ажилтан 7), гэрээт ажилтан 3, 4 ажилтан амаржсаны чөлөөтэй байна. Захиргааны ажилтан 5, эрдэм шинжилгээний ажилтан 44.

Хүснэгт 2. Хүрээлэнгийн ажилтан

Нэгж	Хувь	Тоо
Захиргаа, аж ахуйн алба	10%	5
Философийн салбар	25%	12
Социологи, нийгмийн сэтгэлзүйн салбар	17%	8
Улс төр, эрх зүйн салбар	25%	12
Баян-Өлгий аймаг дахь салбар	16%	7
Шашин судлалын салбар	10%	5

Эрдэм шинжилгээний ажилтнууд өөрийн сонгон судалж буй сэдвийн хүрээнд судалгаа, эрдэм шинжилгээний ажлын ур чадвар, мэдлэг боловсролоо дээшлүүлэн ажиллаж байна.

Хүснэгт 3. Эрдмийн зэрэгтэй ажилтны дундаж нас

№	Эрдмийн зэрэг, цол	Тоо	Үүнээс			
			35 хүртэлх насны	35-50 насны	50-иас дээш насны	Дундаж нас
1	Академич	2	-	-	2	**62**
2	Доктор (Sc.D)	3	-	-	2	**67**
3	Доктор (Ph.D)	14	-	5	9	**49**
4	Магистр	23	17	12	-	**33.5**
5	Бакалавр	2	2	-	-	**28.5**
	Бүгд	44				**48**

Хавсралт 3.

ХҮРЭЭЛЭНГИЙН БҮТЭЭЛ ТУУРВИЛ

1990-ээд оноос өрнө, дорнын болон монголын философи сэтгэлгээний түүх; монголын нийгмийн хөгжил, өөрчлөлтийн асуудал; олон нийтийн санаа бодлын социологийн судалгаа; монголчуудын амьдралын хэв маяг; монголын улс төрийн тогтолцооны онцлог; ардчиллын төлөвшил; буддын философийн онол, түүхийн асуудал; эрх зүйн ухамсар, соёлын төлөвшил; үндсэн хуулийн эрх зүй зэрэг нийгэм, хүмүүнлэгийн салбарын суурь судалгаа явуулж ирсэн. Стратеги төлөвлөгөө боловсруулсан 2017 оноос өмнө 4 жилийн бүтээлийн тоон үзүүлэлтийг дараах графикт харуулав.

График 1. 2013-2016 оны бүтээл




Монголын философийн түүх, өрнө дорнын философийн түүх, онол, эх сурвалжийн судалгаа; монголын нийгмийн өөрчлөлтийг философи, социологи, улс төр судлал, хууль зүйн ухааны үүднээс судлан төр засгийн үйл ажиллагаанд шинжлэх ухааны үндэстэй бодлого боловсруулах онол, арга зүй; нийгмийн өөрчлөлтийн олон талтай асуудлыг социологийн тодорхой судалгаагаар шинжлэх; эрх зүйн тогтолцооны өнөөгийн төлөв байдал, хөгжлийн чиг хандлага, Үндсэн хуулийн эрх зүй; сонгуулийн тогтолцоо, сонгуулийн үйл явц, ардчиллын төлөвшил, туршлага сургамжийн асуудлыг тусгайлан судалж бүтээлүүд нийтлүүлэв.

ХҮРЭЭЛЭНГИЙН САНХҮҮЖИЛТ, СУДАЛГААНЫ ОРЧИН

Шинжлэх ухаан технологийн салбарыг хөгжүүлэх эрх зүйн зохих орчин бүрдсэн хэдий ч төсвөөс олгож буй нийт санхүүжилт нь дотоодын нийт бүтээгдэхүүний 0.17 хувь буюу ойролцоогоор 34.5 тэрбум төгрөг юм. Хүрээлэн ШУТС-аас олгодог санхүүжилтийн 75-80 хувь нь ажилтнуудын цалинд зарцуулагддаг. 2017 оны байдлаар нийт санхүүжилтийн 10 хувь нь эрдэм шинжилгээний зардал болно.

График 2. 2009-2015 оны улсын төсвийн санхүүжилт



Төрийн төсвийн зарцуулалт, өмчийн бүртгэл, ашиглалт, хяналтын талаар:

- Төрийн өмчийн бүртгэл данс бүхий үндсэн ба эргэлтийн хөрөнгө, эрдэм шинжилгээний ажлын материаллаг бааз, техник, тоног төхөөрөмж, бусад эд зүйлсийн ашиглалт, хамгаалалт, бүртгэл хяналтыг сайжруулна.
- Хүрээлэнгийн өмчлөх эрхийг хэрэгжүүлэхтэй холбогдсон бусад эрсдэлийг даван туулах төсвийн төсөөллийг тооцож тусгана.

Төрийн өмч, төсвийн хөрөнгийн зарцуулалтыг Монгол улсын Төсвийн тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн дагуу зохион байгуулж, өмчлөх эрхийг дор дурдсан чиглэлээр хэрэгжүүлнэ.

- Төсвийн хөрөнгө, санхүүгийн эх үүсвэрийг зориулалтын дагуу зарцуулж, бүтээгдэхүүний чанарыг дээшлүүлэх үндсэн хөшүүрэг болгон ашиглана.
- Эрдэмтдийн бүтээл, мэргэжлийн үйлчилгээг зах зээлийн эргэлтэнд оруулах, захиалгат судалгааны ажлын хэрэгжүүлэх замаар орлогын эх үүсвэрийн нэр төрлийг нэмэгдүүлнэ.
- Ажил үйлчилгээ явуулах, бүтээгдэхүүн нийлүүлэх хэрэгцээнд зориулсан төсвийн хөрөнгө, санхүүгийн эх үүсвэрийг зориулалтын дагуу хэмнэлттэй зарцуулж, бүтээгдэхүүний чанарыг дээшлүүлэх үндсэн хөшүүрэг болгон ашиглана.
- Хүний нөөцийн чадавхыг дээшлүүлэхэд төсөв, санхүүгийн бусад эх үүсвэрийг үр ашигтай зарцуулна.

Хавсралт 5.

ХҮРЭЭЛЭНГИЙН БАРИЛГА, БАЙГУУЛАМЖ

Хүрээлэнд 45 эрдэм шинжилгээний ажилтан ажиллаж байгаа ШУА-ийн хүрээлэнгүүдийн нэгдсэн II байрны 1-3-р давхарт 14 өрөө тасалгаа ашиглан үйл ажиллагаа явуулж байна. Тус байрны хурлын танхимыг ашигладаг. Хүрээлэнгийн ажилтнууд Философийн салбар -3 өрөө, Социологи, нийгмийн сэтгэл зүйн салбар -3 өрөө, Улс төр, эрх зүйн салбар -2 өрөө, Шашин судлалын салбар -2 өрөө, Захиргаа аж ахуй -3 өрөө, Мэдээллийн төв -1 өрөөнд байрладаг. Нэг эрдэм шинжилгээний ажилтанд оногдох нэгж талбай бага, ажлын байрны аюулгүй байдал, тохь тухыг сайжруулах засвар үйлчилгээ шаардлагатай.

Социологийн судалгааны үндэсний хэмжээний лаборатори байгуулах санаачилгыг гаргаж, 2014, 2015 онд шаардлагатай хөрөнгийн тооцоог хийн ШУА-ийн Тэргүүлэгчдийн газар, Монгол Улсын Засгийн газраас ШУА-д ажилласан ажлын хэсэгт танилцуулсан бөгөөд шийдвэрлэгдээгүй болно.

Цаашид хүрээлэнгийн ажилтнуудын ажиллах орчин нөхцөлийг сайжруулах чиглэлээр ажлын байр, өрөөнд засвар хийх, ажилтнуудын хэрэглэж байгаа тавилга, ширээн сандал, компьютер, бусад техник хэрэгслийг шинэчлэх зайлшгүй шаардлага байгаа боловч төсөв санхүүгийн боломжгүйгээс байдлаас шалтгаалан хүндрэлтэй байна.

Хавсралт 6.

ҮНЭТ ЗҮЙЛСИЙН ТОВЧ ТАЙЛБАР

“Шинжлэх ухаан ертөнцийн талаар тодорхой байдалд хүрэхийг эрмэлздэг”
Э.Гуссерль

Шинжлэх ухааны хөгжил, дэвшил: Шинжлэх ухааны танин мэдэхүй болон өөрчлөлтийн үйл явцыг илэрхийлнэ. Шинжлэх ухааны салбарт бий болсон онол, арга зүйн шинэ хандлага, шинэ мэдлэг, хувьсгал нь шинжлэх ухааны дэвшил юм. Энэ нь шинэ онол, арга зүйн урьдач нөхцөл, ертөнцийн талаарх шинжлэх ухааны шинэ дүр зураг, тайлбар, үзэл санааг бий болгодог чанарын өөрчлөлт юм.

Шинжлэх ухааны ёс зүй: Шинжлэх ухааны мэдлэгийг бүтээх, эзэмших, түгээн дэлгэрүүлэх, түүний үр дүн, нээлтийг зохистой, зөв ашиглах үйл ажиллагаатай холбоотой ёс суртахууны нийтлэг хэм хэмжээ.

Мэргэшсэн ур чадвар: Мэргэшсэн ур чадвар гэдэг нь тухайн мэргэжилд тавигдах шаардлагуудыг бүрэн хангаж, шинжлэх ухааны хөгжилд бодит хувь нэмэр оруулах мэдлэг, чадвар, хандлагын цогц.

Хамтын ажиллагаа: Эрдэмтдийн шинжлэн судлах, бүтээн туурвих бүхий л үйл ажиллагаа нь тэдний хамтын ажиллагаа, оролцооны үр дүн байдаг. Нийгмийн өмнө тулгамдсан асуудлыг шийдвэрлэх судалгаа хөгжүүлэлтийн ажлыг гүйцэтгэх, практикт нэвтрүүлэхэд төр, шинжлэх ухааны байгууллага, хувийн хэвшлийн хамтын сүлжээ чухал үүрэгтэй.

Олон эшт үзэл: Эрдэмтэд шинжлэх ухааны ертөнц дэх олон янзын таамаглал, дэг сургууль, онол, дүгнэлтийн шүтэн барилдлагыг хүндэтгэн итгэл үнэмшил болгож, үнэнийг эрхэмлэдэг. Буддизмд “эшээр баян” гэдэг нь эх сурвалжийн, судар шастирын өндөр мэдлэгтэй, өөрийн үзэл санаагаа эх судар, түүний тайлбар шастираас эшлэл авч нотлон шинжлэхийг хэлнэ.